ӨМНӨГОВЬ АЙМАГ
СЭВРЭЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 27 өдөр Дугаар 3/14 Сайншанд

Хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дах хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.8 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 02/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Сумын Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх "Тогтвортой хөгжсөн Сэврэй-2028" үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих "Хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих" дэд хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, хэрэгжилтийг удирдан зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг жил бүрийн сумын хөгжлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, хэрэгжилтийн явц үр дүнг жил бүр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга /Б.Батсайхан/-д үүрэг болгосугай.

ДАРГА Ч.ОГТБИШ

4625013028

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн
3/14 дүгээр тогтоолын нэгдүгээр
хавсралт

ХӨДӨӨ АЖ АХУЙ, ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөр боловсруулах нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын Их Хурлаас сүүлийн үед баталсан Малын генетик нөөцийн тухай хууль, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулиуд

1.2. "Алсын хараа-2050" Монгол Улсыг урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хөгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн "Амьдралын чанар ба дундаж давхарга", "Эдийн засаг" 3, 4 дүгээр зорилт, Хөдөлмөрийн эдийн засгийн тэнцвэрийг хангаж, мэдлэгийн эдийн засгийг бүрдүүлж, иргэн бүрийг ажилтай, орлоготой болгоно.

1.3. Аймгийг 2024-2028 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл

1.4. Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны "Өсөлттэй Өмнөговь" хөтөлбөрийн Эдийн засгийн тогтвортой өсөлт, салбарын хөгжлийн бодлогын 3.1.3.8-3.1.3.18 дахь заалт

1.5. Сэврэй сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн "Хөрөнгө оруулалт, эдийн засаг, хөдөө аж ахуйн салбарын өсөлт" заалтыг хэрэгжүүлэх

Хоёр. Хэрэгцээ шаардлага

Сумын эдийн засгийн гол салбар нь мал аж ахуй бөгөөд сумын эрхэм зорилгод "Нутаг дэвсгэртэй экологийн тэнцвэрийг зохистой хадгалан, дэд бүтцийг бий болгож, жижиг дунд үйлдвэрлэл, аялал жуулчлал, газар тариалан, мал аж ахуйн салбаруудыг эрчимтэй хөгжүүлэх, хүн амын тогтвортой, чинээлэг аж төрөх нөхцлийг хангах, өөрийнхөө бүх үйл ажиллагааг өөрөө санхүүжүүлэхэд шилжинэ" гэж заасан.

Одоогоор сумын эдийн засгийн хөгжилд мал аж ахуй голлох байр суурийг эзэлж байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар 383 өрхийн 91970 мал тоолуулсан.

Нийт 336 малчин өрх байгаа нь нийт өрхийн 52.5 хувийг эзэлж байна.

Гурав. Хөтөлбөрийн зарчим

3.1. Монгол Улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм журам, стандартыг мөрдөх

3.2. Экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэн тэргүүнд дэмжих, эрүүл ахуйн шаардлагыг баримтлах

3.3. Байгальд ээлтэй, экологийн тэнцвэрт байдлыг хадгалсан шинэ техник, технологийн дэвшил, инновац, шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх

3.4. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх

Дөрөв. Хөтөлбөрийн зорилго

Мэдлэг боловсрол, мэдээллийн технологийн дэвшил, ногоон үйлдвэрлэлийн технологид суурилсан хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн салбарыг дэмжиж тогтвортой эдийн засгийн өсөлтийг бий болгоход оршино.

Тав. Хөтөлбөрийн зорилт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд дараах 10 зорилтыг дэвшүүлж ажиллана.

5.1.Малчдын орлогыг нэмэгдүүлэх, малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, улирлын нөлөөнөөс бага хамааралтай зорилготой аймгийн "Чинээлэг малчин" хөтөлбөрийг хэрэгжүүлж малын үүлдэр угсааг сайжруулна.

5.2. Малчдын орлогыг нэмэгдүүлэх бэлчээрийн ашиглалтыг сайжруулах зорилгоор усгүй алслагдсан бэлчээрийг усжуулж хуучин худгуудыг засварлана.

5.3. Малчдын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор мал эрүүлжүүлэх ариутгал туулгалт, вакцинжуулалтын ажлыг жил бүр зохион байгуулж шинээр мал угаалгын цэг байгуулж, хуучин мал угаалгын цэгүүдийг сайжруулна.

5.4. Залуу малчид, цөөн малтай өрхийг малжуулах төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, залуу малчдыг өвөлжөө бууцтай болгох ажлыг дэмжин ажиллана.

5.5. Малын тэжээлийн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор бэлчээр хашиж хамгаалах, тэжээлийн ургамлын тариалалтыг нэмэгдүүлнэ.

5.6. Монголын говийн бахархал болсон хоёр бөхт тэмээний ашиг шим, үр өгөөжийг дээшлүүлэх зорилгоор тэмээнээс гарах ашиг шимт бүтээгдэхүүний үнэлэмжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.

5.7. Баяр наадам тэмдэглэн өнгөрүүлэх, хурдан морины уралдаан, морины соёлыг түгээн дэлгэрүүлэх адуучин тэмцээнийг зохион байгуулах

5.8. Эдийн засгаа тэлэх зорилгоор жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж уул уурхайн компаниудад тодорхой бүтээгдэхүүн нийлүүлж орон нутгийн брэнд бүтээгдэхүүнтэй болно.

5.9. Газар тариалан эрхлэх сургалтын бааз суурийг өргөжүүлэн сумын төвийн хүлэмжийн цогцолборын үйл ажиллагааг өргөжүүлнэ.

5.10. Хүнсний хувьсгал үндэсний хөдөлгөөний хүрээнд Хүнсний хангамж-аюулгүй байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн зэрэгцээ хүнсний хяналт шалгалтыг боловсронгуй болгоно.

Зургаа. Хөтөлбөрийн зорилтуудын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

6.1.Малчдын орлогыг нэмэгдүүлэх, малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, улирлын нөлөөнөөс бага хамааралтай зорилготой аймгийн "Чинээлэг малчин" хөтөлбөрийг хэрэгжүүлж малын үүлдэр угсааг сайжруулна.

6.1.1. Ингэний сүү, цагаан идээг зах зээлд борлуулах сувгийг олж хөдөлмөр хөнгөвчлөх тоног төхөөрөмжтэй болох

6.1.2. Мах хадгалах хөргүүр бүхий зоорьтой болох

6.1.3. Мах сүү цагаан идээ борлуулах цэгийг сэргээн засварлаж ашиглалтад оруулах

6.1.4. “Элсний баяр” дээр мал, сүү цагаан идээ борлуулах арга хэмээг зохион байгуулах.

6.1.5. Сайн үүлдрийн хээлтүүлэгчийг малын генетик нөөцөд тулгуурлаж нутагшуулах

6.1.6. Үхэр, хонь, ямаанд зохиомол хээлтүүлэг хийх ажлыг зохион байгуулах

6.1.7. Хурдан удмын морь, тэмээг худалдан авах тээврийн зардлыг дэмжих

6.1.8. Малчдын хөдөлмөрийг үнэлж сумын сайн малчин өрх, аварга төлчин шалгаруулж урамшуулах

6.2. Малчдын орлогыг нэмэгдүүлэх бэлчээрийн ашиглалтыг сайжруулах зорилгоор усгүй алслагдсан бэлчээрийг усжуулж хуучин худгуудыг засварлана.

6.2.1. Усгүй болон үржил шим сайтай газруудыг түшиглэн гүн өрмийн худаг гаргах

6.2.2. Хуучин инженерийн хийцтэй худаг засварлах, байшин барих, нарны усан өргүүр суурилуулах

6.2.3. Тэжээлийн ургамал тариалсан малчдыг бодолгоор дэмжих

6.2.4. Энгийн уурхайн худаг гаргасан болон засаж сайжруулсан иргэдийг дэмжих

6.2.5. Бэлчээр сэлгэн ашиглах зорилгоор өвөлжөө хаваржааны бүсэд хашаа хороо засварласан малчдын бүлгийг дэмжих

6.3. Малчдын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор мал эрүүлжүүлэх ариутгал туулгалт, вакцинжуулалтын ажлыг жил бүр зохион байгуулж шинээр мал угаалгын цэг байгуулж, хуучин мал угаалгын цэгүүдийг сайжруулна.

6.3.1. Бод малын тарилгын цэг байгуулах

6.3.2. Бог малын тарилгын зөөврийн хашаа барих

6.3.3. Бод мал угаах төхөөрөмжтэй болох

6.3.4. Шаардлагатай цэгүүдэд мал угаалгын банн шинээр барих

6.4. Залуу малчид, цөөн малтай өрхийг малжуулах төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, залуу малчдыг өвөлжөө бууцтай болгох ажлыг дэмжин ажиллана.

6.4.1. Цөөн малтай, малжих хүсэлтэй иргэдийг малжуулах төсөлд хамруулах

6.4.2. “Мянгатын хишиг” арга хэмжээг үргэлжлүүлэн зохион байгуулах

6.4.3. Залуу малчдыг өвөлжөөтэй болоход нь зохицуулалт хийж өгөх

6.5. Малын тэжээлийн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор бэлчээр хашиж хамгаалах, тэжээлийн ургамлын тариалалтыг нэмэгдүүлнэ.

6.5.1. Хадлангийн талбай хашиж хамгаалах

6.5.2. Өвөлжөө, хаваржааны бууцны хөлд тэжээлийн ургамал тариалсан малчдыг урамшуулах

6.5.3. Тэжээлийн ургамал тариалах талбайг бэлтгэж, тариалалтыг нэмэгдүүлэх

6.5.4. Малын тэжээлийн дарш бэлтгэх тоног төхөөрөмжтэй болох

6.5.5. Дарш хадгалах агуулахтай болох

6.6. Монголын говийн бахархал болсон хоёр бөхт тэмээний ашиг шим, үр өгөөжийг дээшлүүлэх зорилгоор тэмээнээс гарах ашиг шимт бүтээгдэхүүний үнэлэмжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.

6.6.1. Сумын Засаг даргын нэрэмжит хурдан тором шалгаруулах арга хэмжээг жил бүр зохион байгуулна.

6.6.2. Тэмээ сургаж номхруулсан иргэдэд журам болзлын дагуу спортын мастер олгож урамшуулах

6.6.3. “Тэмээний баяр” арга хэмжээг жил бүр өргөн дэлгэр зохион байгуулах

6.6.4. Ботгоны урамшуулал олгох ажлыг зохион байгуулах. (Сумын хамгийн олон ботго бойжуулсон өрхийг урамшуулах)

6.6.5. Тэмээн соёл, тэмээтэй аялал зохион байгуулах

6.7. Баяр наадам тэмдэглэн өнгөрүүлэх, хурдан морины уралдаан, морины соёлыг түгээн дэлгэрүүлэх адуучин тэмцээнийг зохион байгуулах

6.7.1. Сумын баяр наадмыг зохион байгуулах

6.7.2. “Адуучин”, “Хоолтын хурд”, “Гурван хэцийн хурд”- арга хэмжээг зохион байгуулах

6.8. Эдийн засгаа тэлэх зорилгоор жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж уул уурхайн компаниудад тодорхой бүтээгдэхүүн нийлүүлж орон нутгийн брэнд бүтээгдэхүүнтэй болно.

6.8.1. Худалдаа үйлчилгээний бизнес эрхлэгчдийн зөвлөгөөнийг зохион байгуулах

6.8.2. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн зөвлөгөөнийг зохион байгуулах

6.8.3. Өрхийн үйлвэрлэлийн сургалт зохион байгуулах

6.8.4. Худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэлээ тэлэх зорилготой иргэд хөдөлмөрчдөд төсөл бичих, бизнес төлөвлөгөө боловсруулах зэрэг сургалтыг зохион байгуулна.

6.8.5. Арьс шир боловсруулах үйлдвэрийн үйл ажилгааг эхлүүлэхэд дэмжлэг үзүүлэх

6.8.6. Аялал жуулчлалын бүс нутгийн хүрээнд худалдаа үйлчилгээ эрхлэгч нарыг англи хэлний анхан шатны сургалтад хамруулах.

6.9. Газар тариалан эрхлэх сургалтын бааз суурийг өргөжүүлэн сумын төвийн хүлэмжийн цогцолборын үйл ажиллагааг өргөжүүлнэ.

6.9.1. Сумын төвийн хүлэмжийн цогцолборт мэргэжлийн боловсон хүчнийг ажиллуулах.

6.9.2. Газар тариалан эрхлэгчдийг сургалтад хамруулах

6.9.3. Газар тариалан эрхлэгчдийг бодолгын баримт бичиг төлөвлөгөөтэй болгох

6.9.4. Сумын төвийн газар тарилан эрхлэгчдийн талбайн хашаа хамгаалалтын өнгө үзэмжийг сайжруулах

6.9.5. Хонгорын голд хүнсний ногоо борлуулах цэг байгуулах

6.9.6. “Сонгино” арга хэмжээг зохион байгуулах, нутгийн сорттой болох

6.10. Хүнсний хувьсгал үндэсний хөдөлгөөний хүрээнд Хүнсний хангамж-аюулгүй байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн зэрэгцээ хүнсний хяналт шалгалтыг боловсронгуй болгоно.

6.10.1. Хүнсний үйлдвэрлэлийг сумандаа хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төсөл арга хэмжээнд хамруулна.

6.10.2. Сумандаа хүнс, хоол үйлдвэрлэгчдийн холбоо байгуулах

6.10.3. Хүнсний худалдаа, үйлдвэрлэл, гал тогоо бүхий газруудад улирал бүр хяналт шалгалт хийж, заавар зөвлөмж өгөх.

6.10.4. Хүнсний үйлвэрлэл эрхлэгчид болон тогооч нарыг сургалтад хамруулах.

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт, удирдлага зохион байгуулалт

7.1. Хөтөлбөрийг 2025-2028 онуудад хэрэгжүүлнэ.

7.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүжилт дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

7.2.1. Улсын төсөв

7.2.3. Орон нутгийн төсөв

7.2.4. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгө

7.2.5. Бусад эх үүсвэр

Хөтөлбөрийг удирдан зохион байгуулах, мэдээлэлээр хангах, хэрэгжилтэд хяналт тавих үүргийг сумын Засаг даргын Тамгын газар хариуцан, холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэнэ.

Найм. Хүрэх үр дүн

8.1.Малчдын орлогыг нэмэгдүүлэх, малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, улирлын нөлөөнөөс бага хамааралтай зорилготой аймгийн "Чинээлэг малчин" хөтөлбөрийг хэрэгжүүлж малын үүлдэр угсааг сайжруулсан байна.

8.2. Малчдын орлогыг нэмэгдүүлэх бэлчээрийн ашиглалтыг сайжруулах зорилгоор усгүй алслагдсан бэлчээрийг усжуулж хуучин худгуудыг засварлана.

8.3. Малчдын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор мал эрүүлжүүлэх ариутгал туулгалт, вакцинжуулалтын ажлыг жил бүр зохион байгуулж шинээр мал угаалгын цэг байгуулж, хуучин мал угаалгын цэгүүдийг сайжруулсан байна.

8.4. Залуу малчид, цөөн малтай өрхийг малжуулах төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, залуу малчдыг өвөлжөө бууцтай болгосон байна.

8.5. Малын тэжээлийн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор бэлчээр хашиж хамгаалах, тэжээлийн ургамлын тариалалтыг нэмэгдүүлсэн байна.

8.6. Монголын говийн бахархал болсон хоёр бөхт тэмээний ашиг шим, үр өгөөжийг дээшлүүлэх зорилгоор тэмээнээс гарах ашиг шимт бүтээгдэхүүний үнэлэмжийг нэмэгдүүлсэн байна.

8.7. Баяр наадам тэмдэглэн өнгөрүүлэх, хурдан морины уралдаан, морины соёлыг түгээн дэлгэрүүлэх адуучин тэмцээнийг зохион байгуулсан байна.

8.8. Эдийн засгаа тэлэх зорилгоор жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж уул уурхайн компаниудад тодорхой бүтээгдэхүүн нийлүүлж орон нутгийн брэнд бүтээгдэхүүнтэй болсон байна.

8.9. Газар тариалан эрхлэх сургалтын бааз суурийг өргөжүүлэн сумын төвийн хүлэмжийн цогцолборын үйл ажиллагааг сайжруулсан байна.

8.10. Хүнсний хувьсгал үндэсний хөдөлгөөний хүрээнд Хүнсний хангамж-аюулгүй байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн зэрэгцээ хүнсний хяналт шалгалтыг боловсронгуй болгосон байна.

Ес. Хөтөлбөрийн хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ

9.1. Сумын Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж нь хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг нэгтгэн, сумын Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж, Иргэдийн төлөөлөгчдийн Хуралд тайлагнана.

9.2. Хөдөө аж ахуйн тасаг хөтөлбөрийн хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр гарган Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжид ирүүлж хэвшинэ.

9.3. Хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнг тооцон, иргэдэд ил тод мэдээлнэ.

Арав. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

№	Төсөл арга хэмжээний нэр	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин /2024 он/	Зорилтот түвшин			
				2025	2026	2027	2028
Малчдын орлогыг нэмэгдүүлэх, малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, улирлын нөлөөнөөс бага хамааралтай зорилготой аймгийн "Чинээлэг малчин" хөтөлбөрийг хэрэгжүүлж малын үүлдэр угсааг сайжруулна.							
1	1.1 Ингэний сүү, цагаан идээг зах зээлд борлуулах сувгийг олж хөдөлмөр хөнгөвчлөх тоног төхөөрөмжтэй болох	Борлуулалтын тоо хэмжээгээр	Жилд 500-900 ингэ ботголдог	10 тн	20 тн	30 тн	40 тн
	1.2 Мах хадгалах хөргүүр бүхий зоорьтой болох	Тоо	байхгүй	0	1	0	0
	1.3 Мах сүү цагаан идээ борлуулах цэгийг сэргээн засварлаж ашиглалтад оруулах	Хувь	Мах сүү цагаан идээ борлуулах цэгт	100 %	0	0	0
	1.4 "Элсний баяр" дээр амьд мал борлуулах арга хэмжээг зохион байгуулах	Борлуулалтын тоогоор	Хонгорын голын айл өрхүүд бог мал худалдаалдаг	20	30	35	50
	1.5 Сайн үүлдрийн хээлтүүлэгчийг малын	Хээлтүүлэгчийн тоо	2024 онд Уулын бор үүлдрийн	10	2	2	2

	генетик нөөцөд тулгуурлаж нутагшуулах		12 ухнан ишиг авсан				
	1.6 Үхэр, хонь, ямаанд зохиомол хээлтүүлэг хийх ажлыг зохион байгуулах	Зохиомол хээлтүүлгийн тоо	Байхгүй	30	100	300	500
	1.7 Хурдан удмын морь, тэмээг худалдан авах тээврийн зардлыг дэмжих	Малын тоо	2024 онд төв аймгаас хурдан удмын үрээ, Баянхонгор аймгаас хурдан удмын тором зэргийг авсан	3	5	3	5
	1.8 Малчдын хөдөлмөрийг үнэлж сумын сайн малчин өрх, аварга төлчин шалгаруулж урамшуулах	Малчин өрхийн тоо	2024 онд сумын сайн малчин 6, аварга төлчин 1 тус тус тодруулсан	4	4	4	4
Малчдын орлогыг нэмэгдүүлэх бэлчээрийн ашиглалтыг сайжруулах зорилгоор усгүй алслагдсан бэлчээрийг усжуулж хуучин худгуудыг засварлана.							
2	2.1 Усгүй болон үржил шим сайтай газруудыг түшиглэн гүн өрмийн худаг гаргах	Худгийн тоо	Жил бүр шинээр 2-оос багагүй худаг гаргадаг	2	2	2	2
	2.2 Хуучин инженерийн хийцтэй худаг засварлах, байшин барих, нарны усан өргүүр суурилуулах	Худгийн тоо	Жил бүр 2 худаг засварладаг	2	2	2	2
	2.3 Тэжээлийн ургамал тариалсан малчдыг бодолгоор дэмжих	Талбайн хэмжээ	Жилд 0.02 га талбайд тариалалт хийдэг	1 га	2 га	2 га	2 га

	2.4 Энгийн уурхайн худаг гаргасан болон засаж сайжруулсан иргэдийг дэмжих	Сэргээн засварласан худгийн тоо	Гар худгийг лайдах, ам таглааг засаж сайжруулах, байшинтай болгох зэрэг ажлууд хийгддэг	2	3	3	4
	2.5 Бэлчээр сэлгэн ашиглах зорилгоор өвөлжөө хаваржааны бүсэд хашаа хороо засварласан малчдын бүлгийг дэмжих	Сэргээн засварлсан хашаа хорооны тоо	Хуучны хашаа хороогоо хамтарч сэргээн засварлада г	2	2	2	2
Малчдын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор мал эрүүлжүүлэх ариутгал туулгалт, вакцинжуулалтын ажлыг жил бүр зохион байгуулж шинээр мал угаалгын цэг байгуулж, хуучин мал угаалгын цэгүүдийг сайжруулна							
3	3.1 Бод малын тарилгын цэг байгуулах	Цэгийн тоо	байхгүй	0	1	1	1
	3.2 Бог малын тарилгын зөөврийн хашаа барих	Хашааны тоо	Хуучин хашаа нь зөөвөрлөхөд овор их, хүнд байдаг	0	1	0	0
	3.3 Бод мал угаах төхөөрөмжтэй болох	Төхөөрөмжийн тоо	байхгүй	0	0	1	0
	3.4 Шаардлагатай цэгүүдэд мал угаалгын банн шинээр барих	Шинээр барьсан банны тоо	Ашиглаж байгаа 22 банн байгаа	0	1	1	1
Залуу малчид, цөөн малтай өрхийг малжуулах төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, залуу малчдыг өвөлжөө бууцтай болгох ажлыг дэмжин ажиллана.							
4	4.1 Цөөн малтай малжих хүсэлтэй иргэдийг малжуулах төсөлд хамруулах	Малжих хүсэлтийн тоо	2024 онд нийт 6 малчин өрх малжуулах төсөлд хамрагдсан	4	4	4	4

	4.2 Мянгатын хишиг арга хэмжээг үргэлжлүүлэн зохион байгуулах	Хамрагдсан өрхийн тоо	Мянгатын хишиг хөтөлбөртнийт 14 өрх хамрагдсан байна	2	0	0	2
	4.3 Залуу малчдыг өвөлжөөтэй болоход нь зохицуулалт хийж өгөх	Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн хувь	Залуу малчин өрхүүдэд өвөлжөө бууц олддоггүй	75%	80%	90%	100%
Малын тэжээлийн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор бэлчээр хашиж хамгаалах, тэжээлийн ургамлын тариалалтыг нэмэгдүүлнэ.							
5	5.1 Хадлангийн талбай хашиж хамгаалах	Талбайн хэмжээ	Хашсан талбай байхгүй	2 га	3 га	4 га	5 га
	5.2 Өвөлжөө хаваржааны бууцны хөлд тэжээлийн ургамал тариалсан малчдыг урамшуулах	Өрхийн тоо	2 малчин өрх туршиж үзсэн	3	4	5	6
	5.3 Тэжээлийн ургамал тариалах талбайг бэлтгэж тариалалтыг нэмэгдүүлэх	Талбайн хэмжээ	0.02 га талбайд тариалалт хийдэг	1	2	2	2
	5.4 Малын тэжээлийн дарш бэлтгэх тоног төхөөрөмжтэй болох	Иж бүрэн тоног төхөөрөмжийн тоо	байхгүй	1	2	2	2
	5.5 Дарш хадгалах агуулахтай болох	Гүйцэтгэлийн хувь	байхгүй	0	30%	70%	0
Монголын говийн бахархал болсон хоёр бөхт тэмээний ашиг шим, үр өгөөжийг дээшлүүлэх зорилгоор тэмээнээс гарах ашиг шимт бүтээгдэхүүний үнэлэмжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.							
6	6.1 Сумын Засаг даргын нэрэмжит хурдан торомны уралдаан зохион байгуулна.	Гүйцэтгэлийн хувь	шинээр	100 %	100 %	100 %	100%
	6.2 Тэмээ сургаж номхруулсан иргэдэд журам болзлын дагуу	Тоо	Хуучин хангал сургалтын	2	2	2	2

	спортын мастер олгож урамшуулах		спортын мастер олгодог байсан				
	6.3 Тэмээний баяр арга хэмжээг жил бүр өргөн дэлгэр зохион байгуулах	Гүйцэтгэлийн хувь	Жил бүр зохион байгуулдаг	100 %	100 %	100 %	100%
	6.4 Ботгоны урамшуулал олгох ажлыг зохион байгуулах. (Сумын хамгийн олон ботго бойжуулсон өрхийг урамшуулах)	Ботгоны тоо	жил бүр 300-900 ботгонд олгодог	350	700	600	900
	6.5 Тэмээн соёл, тэмээтэй аялал зохион байгуулах	Оролцогчийн тоо	байхгүй	15	20	20	20
Баяр наадам тэмдэглэн өнгөрүүлэх, хурдан морины уралдаан, морины соёлыг түгээн дэлгэрүүлэх адуучин тэмцээнийг зохион байгуулах							
7	7.1 Сумын баяр наадмыг зохион байгуулах	Хурдан морьдын тоо	Жил бүр зохион байгуулдаг	60-100	60-100	60-100	60-100
	7.2 “Хоолтын хурд” арга хэмжээг зохион байгуулах	Хурдан морьдын тоо	Жил бүр зохион байгуулдаг	60-100	60-100	60-100	60-100
	7.3 “Гурван хэцийн хурд”-ыг зохион байгуулах	Хурдан морьдын тоо	Жил бүр зохион байгуулдаг	60-100	60-100	60-100	60-100
	7.4 “Адуучин” тэмцээнийг зохион байгуулах	Хурдан морьдын тоо	байхгүй	5-10	5-10	5-10	5-10
Эдийн засгаа тэлэх зорилгоор жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж уул уурхайн компаниудад тодорхой бүтээгдэхүүн нийлүүлж орон нутгийн брэнд бүтээгдэхүүнтэй болно.							
8	8.1 Худалдаа үйлчилгээний бизнес эрхлэгч зөвлөгөөнийг зохион байгуулах	Хамрагдах хүний тоо	байхгүй	15-30	15-30	15-30	15-30
	8.2 Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн	Хамрагдах хүний тоо	байхгүй	15-30	15-30	15-30	15-30

	зөвлөгөөнийг зохион байгуулах						
	8.3 Өрхийн үйлвэрлэлийн сургалт зохион байгуулах	Хамрагдах хүний тоо	байхгүй	15-30	15-30	15-30	15-30
	8.4 Худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэлээ тэлэх зорилготой иргэд хөдөлмөрчдөд төсөл бичих, бизнес төлөвлөгөө боловсруулах зэрэг сургалтыг зохион байгуулна.	Хамрагдах хүний тоо	байхгүй	15-30	15-30	15-30	15-30
	8.5 Арьс шир боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг эхлүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Гүйцэтгэлийн хувь	Үйлдвэрийн байшин болон тоног төхөөрөмж байгаа	100	100	100	100
	8.6 Аялал жуулчлалын бүс нутгийн хүрээнд худалдаа үйлчилгээ эрхлэгч нарыг англи хэлний анхан шатны сургалтад хамруулах.	Хамрагдах хүний тоо	байхгүй	15-30	15-30	15-30	15-30
Газар тариалан эрхлэх сургалтын бааз суурийг өргөжүүлэн сумын төвийн хүлэмжийн цогцолборын үйл ажиллагааг өргөжүүлнэ.							
9	9.1 Сумын төвийн хүлэмжийн цогцолборт мэргэжлийн боловсон хүчнийг ажиллуулах	Боловсон хүчний тоо	Сургалтын төв хүлэмжийн цогцолбор байгаа	2	2	2	2
	9.2 Газар тариалан эрхлэгчдийг сургалтад хамруулах	Хамрагдах хүний тоо	байхгүй	15-30	15-30	15-30	15-30
	9.3 Газар тариалан эрхлэгчдийг бодолгын баримт бичиг төлөвлөгөөтэй болгох	Гүйцэтгэлийн хувь	Газар тариалан эрхэлдэг 21 иргэн байгаа	20%	30%	50%	100%
	9.4 Сумын төвийн газар тарилан эрхлэгчдийн талбайн хашаа	Талбайн хэмжээ	Сумын төвд байгаа задгай	0	1.6	1.6	0

	хамгаалалтын өнгө үзэмжийг сайжруулах		талбай нийтдээ 3.2 га байдаг				
	9.5 Хонгорын голд хүнсний ногоо борлуулах цэг байгуулах	Цэгийн тоо	байхгүй	0	1	0	0
	9.6 “Сонгино” арга хэмжээг зохион байгуулах, нутгийн сорттой болох	Ургацын хэмжээ	2024 онд 1.8 тн ургац хураан авсан	2.0	3.0	3.0	3.0
Хүнсний хувьсгал үндэсний хөдөлгөөний хүрээнд Хүнсний хангамж-аюулгүй байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн зэрэгцээ хүнсний хяналт шалгалтыг боловсронгуй болгоно.							
10	10.1 Хүнсний үйлдвэрлэлийг сумандаа хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төсөл арга хэмжээнд хамруулна.	Үйлдвэрийн тоо	Талх нарийн боовны цех 1, гал тогоо бүхий газар 4 байна	5	6	8	10
	10.2 Сумандаа хүнс, хоол үйлдвэрлэгчдийн холбоо байгуулах	Гүйцэтгэлийн хувь	байхгүй	100 %	100 %	100 %	100%
	10.33 Хүнсний худалдаа, үйлдвэрлэл, гал тогоо бүхий газруудад улирал бүр хяналт шалгалт хийж, заавар зөвлөмж өгөх.	Хяналтын тоо	Жилдээ 4-өөс цөөнгүй хяналт шалгалт хийдэг байсан	4	4	4	4
	10.4 Хүнсний үйлвэрлэл эрхлэгчид болон тогооч нарыг сургалтад хамруулах.	Хамрагдах хүний тоо	байхгүй	5-10	5-10	5-10	5-10

-oOo-

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн
3/14 дүгээр тогтоолын хоёрдугаар
хавсралт

ХӨДӨӨ АЖ АХУЙ, ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч : Сумын Засаг даргын орлогч

Гишүүдэд: Х.Батдэлгэр (ИТХ-ын Төлөөлөгч)

П.Бөхчулуун (ИТХ-ын Төлөөлөгч)

Сайншанд багийн Засаг дарга

Хоолт багийн Засаг дарга

Бүйлсэн багийн Засаг дарга

Засаг даргын Тамгын газрын Тархвар зүйч

Засаг даргын Тамгын газрын Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичиг: Засаг даргын Тамгын газрын Малын үржил, бүртгэл, мэдээллийн асуудал хариуцсан мэргэжилтэн

-oOo-